



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 02

№ 01/03 ДҮА-2018/12/СТА-ОНТС Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сум хөгжүүлэх сангийн 2017 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийх явцад зээлдэгчдэд мэргэжил арга зүйн сургалтад зориулах зардлаас 398,000.00 / гурван зуун ерэн найман мянган/ төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.8-д /Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна./ заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д/Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д / төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/, 4.1.5-т /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцөлийг хангаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Сум хөгжүүлэх сангийн журмын дагуу хөрөнгийг зарцуулж, зөрчлийг арилган, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурвансайхан сумын Засаг дарга Л.Өлзийбат, нягтлан бодогч Д.Баярцэнгэл нарт хариуцуулав.

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР  Д.ДОЛЖИНСҮРЭН

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ  
НЯГТЛАН БОДОГЧ

  
Л.ӨЛЗИЙБАТ  
Д.БАЯРЦЭНГЭЛ

<sup>1</sup>Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/